

Монгол ноолуурын өртгийн сүлжээнд хийсэн шинжилгээ

Өртгийн сүлжээнд хийсэн шинжилгээ нь бодлогын чиг баримжаа гаргах, хэлэлцүүлэг хийх, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мэдээллээр хангахад хувь нэмэр оруулдаг. Энэхүү шинжилгээг явуулснаар хөдөө аж ахуй, усны амьтны үржүүлэг болоод загасны аж ахуй зэрэг сүлжээний хөгжил зах зээлийн зарчимд хэр таарч байгааг ойлгоход тустай бөгөөд байгаль орчин, нийгэм, жижиг бизнес эрхлэгчдэд үзүүлэх үр нөлөөг үнэлдэг юм. Европын Комиссоос өртгийн сүлжээний нэгдсэн аргачлалыг стандартчилж өгсөн байдаг (https://capacity4dev.europa.eu/projects/value-chain-analysis-for-development-vca4d/info_en). Тус аргачлалын гол зорилго өртгийн сүлжээ нь нийгэм ба байгаль орчны аль алинд хэр тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг буй болгох боломжийг олгож байгааг ойлгоход оршдог.

Өртгийн сүлжээний агуулга

Монгол улс нь байгалийн нөөц баялаг ихтэй, далайд гарцгүй, 3.29 сая хүн амтай нь хүн амын нягтшил хамгийн багатай дэлхийн улсын нэг юм. Нийт газар нутгийн хэмжээ нь 1.5 сая километр квадрат нутаг дэвсгэртэй ба түүний 4/3-ийг бэлчээр эзэлдэг.

Монгол улсын эдийн засгийн ихэнх хувийг уул уурхайн үйлдвэрлэлээс бүрдүүлдэг. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн нь эрдэс баялгийн бүтээгдэхүүний дараа орох хоёрдогч том экспортын орлого бүрдүүлэгч салбар.

Монгол улсын түүхий ноолуурын үйлдвэрлэлийн хэмжээ 10,000 тонн орчим байгаа нь БНХАУ-ы дараа орох дэлхийн хоёрдогч том түүхий ноолуур үйлдвэрлэгч төдийгүй ноолууран утас болон ноолууран хувцасны хоёрдогч том экспортлогч орон.

Монголын ноолуур үйлдвэрлэл нь нийгэм, түүх, соёлын давтагдашгүй шинжийг агуулсан уламжлалт мал маллагааны нөхцөлд явагдаж байгаагаараа онцлогтой ч ноолуурын үнийн өсөлтийг дагаж ямааны тоо толгой бусад малынхаас харьцангуй нэмэгдэж байгаа нь байгаль орчинд сөрөг нөлөөллийг үүсгэж байна.

Ноолуур боловсруулалтын салбар нь ялангуяа суурин газрын эмэгтэйчүүдэд цалин өндөртэй ажлын байрыг буй болгож байна.

Ноолуурын өртгийн сүлжээнд Европын Холбооны оролцоо

Монгол Улсын Засгийн газар COP26-ийн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод санаачилга”-аар дамжуулан ноолуурын нэмүү өртгийн сүлжээний (VC) тогтвортой хөгжлийг дэмжих чиглэлээр ажиллаж байна. Ойн устгал болон уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх зорилт нь ажлын байр бий болгох, хүнсний хангамжийг сайжруулахтай хосолсноор үндэсний гол түүхий эд болох ноолуурыг стратегийн өртгийн сүлжээний хүрээнд тодорхойлон төрөлжүүлэх, хувирган өөрчлөхөд түлхэц өгч байна.

Европын Холбооны Монгол дахь Төлөөлөгчийн газар нь дээрх үндэсний хэмжээний санаачилгыг Европын Холбооны 2021-2027 оны Хамтын ажиллагааны хөтөлбөрөөр (MIP 2021-2027) дамжуулан дэмжин ажиллаж байна. Энэхүү MIP хөтөлбөрт Монгол Улсыг ногоон эдийн засагт шилжих үйл явцыг бэхжүүлэх үйл ажиллагааны хүрээнд ноолуурын салбарыг оруулан стратегийн өртгийн сүлжээнд анхаарлаа хандуулж, “Хөдөөгийн хөгжилд тогтвортой экосистем ба хөдөө аж ахуйн менежмент” гэж тодорхойлоод байна.

Мөн Европын Холбоо нь 2018-2022 оны хооронд Тогтвортой Сүлжмэлийн үйлдвэрлэл ба эко-шошгожуулалт STeP EcoLab төслийг Монголд хэрэгжүүлсэн юм.




ГРАФИК 1. ӨРТГИЙН СҮЛЖЭЭНИЙ УРСГАЛ

Үйл ажиллагааны шинжилгээ

2022 он гэхэд ямааны тоо толгой **27,5 саяд** (нийт мал сүргийн 38%) хүрч түүхий ноолуурын хэмжээ **9,672** тонн болсон. Ноолуурын бэлтгэн нийлүүлэлтийг бүсчлэн авч үзвэл төвийн бүсэд 27%, зүүн бүс 13%, хангайн бүсээс 29%, байсан бол баруун бүсээс 31 хувийг бэлтгэсэн байна.

Малчид ноолуурыг гар аргаар самнадаг ба зүүн бүсийн аймгууд гуравдугаар сараас эхэлж баруун бүсийн аймгууд зургаадугаар сар хүртэл самнадаг. Хамгийн чанартай ноолуур зүүн бүсийн аймгуудаас бэлтгэдэг тул үнэ нь хамгийн өндрөөр тогтдог.

Цөөн малтай болон **олон толгой малтай** малчдаас судалгаа авч үзэхэд цөөн малтай малчинд дунджаар 95 ямаатай өрхийг хамруулсан бол олон малтай малчинд дунджаар 340 ямаатай өрхийг хамрууллаа. Хоёулаа мал маллагааны хувьд ижил боловч зардлын хувь харьцангуй өөр байна (туслах малчин, ачааны машин, том ферм тоног төхөөрөмжийн өндөр элэгдэл хорогдлын зардал).

Ноолуурын өртгийн сүлжээ	Нийт/ дундаж	Зүүн бүс	Төвийн бүс	Хангайн бүс	Баруун бүс
ноолуурын гарц /кг, ямаа тутам/	0.351	0.309	0.363	0.312	0.408
Ямааны тоо /мянган толгой/	27,569	4,301	7,191	8,907	7,441
Ноолуурын үйлдвэрлэлийн хэмжээ /тонн/	9,672	1,246	2,611	2,779	3,036
*цөөн малтай малчин өрх	5,685	732	1,535	1,633	1,785
*олон малтай малчин өрх	3,987	514	1,076	1,146	1,251
Ямаатай өрхийн тоо	211,549	28,174	50,687	76,199	56,489
*Цөөн малтай малчин өрх	180,549	21,694	42,222	66,293	50,332
*олон малтай малчин өрх	31,008	6,480	8,465	9,906	6,157

ГРАФИК 2. МОНГОЛ УЛСЫН НОЛУУРЫН ӨРТГИЙН СҮЛЖЭЭНИЙ ТӨЛӨВ БАЙДАЛ

Монгол улсын ноолуурын өртгийн сүлжээ нь хоёр гол дэд сүлжээнээс тогтож байна. i) **түүхий ноолуур экспортлох дэд сүлжээ** нь угаасан түүхий ноолуурыг Хятад улсруу шууд экспортод гаргах, ii) **босоо хамааралт дэд сүлжээ** нь боловсруулалтын янз бүрийн шатыг хамарсан.

Түүхий ноолуурын дэд сүлжээ

Тухайн жилд үйлдвэрлэсэн нийт ноолуурын 75 хувь нь түүхий ноолуурын дэд сүлжээнд хамрагдана. Түүхий ноолуурыг малчдаас ченжүүд авч угаах үйлдвэрт шууд нийлүүлдэг ба угаасны дараа ихэнхдээ Хятад улсруу экспортлогддог (график 1). Энэхүү дэд сүлжээ ноолуурын үнэ цэнийг нэмэгдүүлэх болон эх орондоо ажлын байр буй болгох зорилгоор батлагдсан 0,3 хувь хүртэл завсрын үсний агууламжтай боловсруулаагүй ноолуурын экспортыг хязгаарласан техникийн зохицуулалт (Засгийн газрын 380/2022 дугаар тогтоолын хавсралт)-аар ихээхэн өөрчлөгдөх төлөвтэй байна.

Босоо хамааралт дэд сүлжээ

Босоо хамааралт дэд сүлжээний үйл явц нь түүхий ноолуурын салбарын 25 хувийг эзэлнэ. Энэхүү дэд сүлжээ дараах боловсруулах үе шатыг хамардаг. Үүнд: ноолуур завсрын зуучлагч буюу ченжээр бэлтгэгдэнэ (анхан шатны ба дундын хоршоод, ченжүүд), ангилах, угаах, самнах, будах, ээрэх, сүлжих, оёх буюу эцсийн бүтээгдэхүүн нэхэх гэх мэт. Ноолуурын тал хувь нь самнасан байдлаар бусад орон луу экспортод гардаг ба ихэнх хэсэг нь Итали улсруу гарч дахин боловсруулагддаг. Ноолуурын эцсийн бүтээгдэхүүн нь Европын орнууд, АНУ, Англи, Солонгос гэх улсын зах зээлд болон дотоод зах зээлд борлуулагдаж байна.

Засаглал

Ноолуурын өртгийн сүлжээний засаглалд гол тоглогчдоос гадна Засгийн Газрын байгууллагууд, хувийн болон иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллагууд оролцдог (Схем зураг 3). Монголын улсын Засгийн Газар уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, хүнсний хангамжийн найдвартай байдлыг хангадаг эдийн засгийн үр ашигтай, тогтвортой мал аж ахуйн салбарыг хөгжүүлэхийг зорьж байна. Олон улсын хандивлагч байгууллагуудын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй Засгийн газрын гол стратеги нь бэлчээрийн тогтвортой менежмент, нүүдлийн тогтолцоонд суурилсан өртөг шингээсэн малын гаралтай бүтээгдэхүүний сүлжээг хөгжүүлэх явдал юм

Иргэний нийгмийн байгууллагуудын бодлогын хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалт, ялангуяа бэлчээрийн талаарх хэлэлцүүлэгт малчдын дуу хоолойг илэрхийлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Монгол улсад малчны болон үйлдвэрийн түвшний баталгаажуулалтын нэлээд хэдэн схем байгаа ч хоорондын уялдан зохицуулалт, Засгийн газарт хүлээн зөвшөөрөгдөх байдал бага байна. Тухайлбал Хариуцлагатай нүүдэлчин бэлчээрийн мал аж ахуйн зохистой дадлын стандартыг улам илүү олонд таниулахын тулд Хил хязгааргүй малын эмч нарын S3C стандартын схемтэй нэгтгэн бэлчээрийн ноолуурын схемийг боловсруулж байна. Ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрүүдийн тухайд ноос ноолуурын холбоо Текстилийн тогтвортой байдлын стандарт болох MNS 6926:2021 дагуу албан ёсны эрхтэйгээр үнэлгээ баталгаажуулалт хийж байгаа ба Хаан ширхэгт стандартыг эрхийг мөн эзэмшиж байна.

Малчид янз бүрийн хоршоо, Бэлчээр Ашиглагчдын Хэсэг, гэх мэт малчдын хамтыг байгууллага байгуулан хамтран ажиллаж байгаа ч тэдгээрийн хоорондын уялдаа холбоо ихэвчлэн сул байна. Хоршоодын санхүүгийн чадавх сул байгаа нь малчдыг бэлэн мөнгөний урьдчилгаа олгодог дундын зуучлагчид, ченжүүдээс илүү хамааралтай болгож байна.




График 3. ЗАСАГЛАЛЫН СХЕМ

Ноолуурын өртгийн сүлжээний эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө юу вэ?

Дотоодын эдийн засагт үзүүлэх нөлөө

2022 онд ноолуурын өртгийн сүлжээгээр буй болгосон **нэмэгдсэн өртөг** 1,919 тэрбум MNT (€581 сая) байсан ба 96 хувь нь ноолуур өртгийн сүлжээний оролцогчдоос (малчид, үйлдвэр, худалдан борлуулагчид) шууд нэмэгдсэн өртөг, үлдсэн 4 хувь нь нийлүүлэгчдийн бараа үйлчилгээнээс (малын тэжээл, бензин тос, ус, малын эрүүл мэндийн үйлчилгээ, угаах, даатгал гэх мэт) шууд бусаар нэмэгдсэн өртөг байна.

Нийт нэмэгдсэн өртөг нь Үйл ажиллагааны цэвэр ашиг (NOP) (74%, үүнээс цөөн малтай малчид 40%, олон малтай малчид 25%), зээлийн хүү (10%) болон элэгдлийн зардал (7%) тус тус бүрдэж байна. (График 4).

Үндэсний дотоодын нийт бүтээгдэхүүнд бүхий л өртгийн сүлжээний оруулах нэмэр ойролцоогоор 4 хувь бол малчид, фермерийн ХАА-н дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь нь их буюу 27.4 хувь байна.

Ноолуурын өртгийн сүлжээний улс орны эдийн засагт үзүүлэх нөлөө нь 62,056 сая төгрөгийн (18,8 сая евро) **эерэг байсан нь** тус салбараас төлсөн тухайн өртгийн сүлжээний салбарт гарч байгаа зардлаас илүү байсан аж. **Интеграцийн түвшин** 91% байгаа нь нэмүү өртгийн сүлжээний үйлдвэрлэлийн үнэ цэнийн ихээхэн хэсэг нь дотоодын эдийн засагт үлдсэн гэсэн үг.




График 4. НОЛУУРЫН САЛБАРЫН НЭМЭГДСЭН ӨРТГИЙН ХУВААРИЛАЛТ

Ноолуурын дэд сүлжээ ба өртгийн сүлжээний үе шатанд бүрдсэн нэмэгдсэн өртөг

Түүхий ноолуурын сүлжээний нэмэгдсэн өртгийн дэд сүлжээнд ихээхэн хэмжээний ноолуур нийлүүлэгдсэнээр 64% шууд нэмэгдсэн өртөг буй болгосон бол босоо хамааралт дэд сүлжээ 36 хувийн нэмэр оруулж байна. **Хэдий тийм боловч түүхий ноолуурыг дараагийн шатанд боловсруулснаар (€84 мянган/тонн) өртөг шингээж байгаа нь түүхий ноолуур борлуулах дэд сүлжээтэй (€49 мянган/тонн) харьцуулахад хамаагүй илүү нэмэгдсэн өртөгтэй байгаагаас харахад салбарыг дараагийн шатанд боловсруулах дэд сүлжээг хөгжүүлэх зайлшгүй шаардлагатайг харуулж байна.**

Босоо хамааралт өртгийн сүлжээний үе шатуудын дотроос ноолуур үйлдвэрлэл нь шууд нэмэгдсэн өртгийн (74%), дараа нь боловсруулалт (22%) болон худалдаа (4%) хувийг тус тус бүтээж байна.

Ноолуурын өртгийн сүлжээний оролцогчдын санхүүгийн боломжит байдал

Ноолуурын сүлжээнд оролцогчдын бүх **үйл ажиллагаа бүгд ашигтай** байдгийг График 5-р харуулсан. Малчид түүхий эдийн бага орцын улмаас өндөр түүхий эдийн үйл ажиллагааны ашиг (NOP) болон эргэлтийн ашиг (ROT)-тай харагдаж байна. Малчдын гол зардлууд нь тэжээл, тээврийн шатахуун, зээлийн хүү болон элэгдэл юм. Ноолуурын өртгийн сүлжээний доод урсгалын оролцогчдын санхүүгийн төлөв байдал илүү ээдрээтэй учир нь боловсруулагчид өндөр үнэтэй ноолуур худалдаж авахын тулд 3-6 саруудад өндөр хүүтэй зээл болон өрийн санхүүжилт шаарддаг бөгөөд энэ нь ноолуурын боловсруулалтын салбарын хөгжлийг удаашруулах хүчин зүйлсийн нэг болж байна.

Оролцогчид	Жилийн нийт үйл ажиллагааны орлого (NOP)	Эргэлтийн ашиг* (%)
Цөөн малтай өрх, Зүүн бүс	5,070,042 MNT (€1,535)	75%
Цөөн малтай өрх, Төвийн бүс	4,700,000 MNT (€1,422)	74%
Бага малтай өрх, Хангайн бүс	4,508,470 MNT (€1,365)	73%
Цөөн малтай өрх, Баруун бүс	4,982,000 MNT (€1,508)	75%
Олон малтай өрх, Зүүн бүс	14,026,805 MNT (€4,250)	75%
Олон малтай өрх, Төвийн бүс	12,705,536 MNT (€3,850)	74%
Олон малтай өрх, Хангайн бүс	12,038,470 MNT (€3,645)	73%
Олон малтай өрх, Баруун бүс	13,713,777 MNT (€4,153)	75%
Ченж	10,927,148 MNT (€3,309)	0.80%
Экспортлогч-угаагаад (түүхий ноолуурын сүлжээ)	1,077,538,140 MNT (€326,328)	4.60%
Экспортлогч-самнаад (босоо хамааралт өртгийн сүлжээ)	942,620,580 MNT (€285,469)	15.40%
Их хэмжээний эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч (босоо хамааралт өртгийн сүлжээ)	453,568,663 MNT (€137,361)	22%
Small apparel producer (босоо хамааралт өртгийн сүлжээ)	345,387,000 MNT (€104,599)	6%
Жижиглэн (босоо хамааралт өртгийн сүлжээ)	92,164,047 MNT (€27,911)	3.40%

* Жилийн нийт үйл ажиллагааны орлого (NOP): элэгдлийг хассан цэвэр орлого

* Эргэлтийн ашиг: үйл ажиллагааны орлого/бүтээгдэхүүн

График 5. Ноолуурын өртгийн сүлжээний тоглогчдын санхүүгийн боломжит байдал

Олон улсын эдийн засгийн боломжит байдал

Нэрлэсэн хамгаалалтын илтгэлцүүрийг (Nominal Protection Coefficient) 1 гэж тооцсон бөгөөд энэ нь олон улсын үнээр тооцох тохиолдолд цалин ижил байна гэсэн үг юм. **Дотоодын нөөцийн зардлын харьцаа** нь 0.08 бөгөөд **олон улсын эдийн засгийн харьцангуй давуу тал**, тогтвортой чадварыг илэрхийлдэг. Тиймээс, олон улсын зах зээл, дотоодын хүчин зүйлсийн цалин хөлсийг харгалзан үзэхэд өртгийн сүлжээний үйл ажиллагаанд ашигладаг дотоодын хүчин зүйлсийн үнэ цэнэ нь тэдний үйлдвэрлэсэн үнэ цэнээс доогуур байна.

Тиймээс, олон улсын зах зээл, дотоодын үйлдвэрүүдийн цалин хөлсийг харгалзан үзэхэд өртгийн сүлжээний үйл ажиллагаанд ашигладаг дотоодын үйлдвэрийн үнэ цэнэ нь тэдний үйлдвэрлэсэн үнэ цэнээс доогуур байна.

Монголын ноолуурын өртгийн сүлжээ нь малчин өрхийн орлогын томоохон эх үүсвэрт тооцогддог учир чухал ач холбогдолтой байна. Ноолуурын өртгийн сүлжээ нь хөдөө аж ахуйн салбараас оруулах ДНБ-д 27 хувийг бүрдүүлэхээс гадна экспорт, татвар зэргээр үндэсний эдийн засагт томоохон эерэг нөлөө үзүүлж байна. Малчин өрхийн тухайд ноолуурын өртгийн сүлжээ нь санхүүгийн хувьд ашигтай, тогтвортой гэдэг нь батлагдаж байна. Харин боловсруулах үйлдвэрийн шатанд санхүүгийн нөхцөл байдал хүндрэлтэй байна. Хамгийн их бэрхшээлтэй нөхцөл байдал нь үйлдвэрлэлийн шатанд ноолуурыг боловсруулах нь их хугацаа, хөрөнгө, хүн хүчний зардал шаарддаг байна.

Эдийн засгийн үр ашиг нь хүртээмжтэй эсэх?

Өртгийн сүлжээний оролцогчдын дунд орлогын тархалт

Өртгийн сүлжээний нийт тоглогчдын үйл ажиллагааны орлого нь 1,384,693 сая MNT (€419.3 сая)-тай тэнцүү байсан бол цөөн болон олон малтай өрхийн орлого нь түүний 90 (55% болон 35%) хувьтай тэнцэж байна. Малчин өрхийн тоотой харьцуулахад харьцангуй цөөхөн боловсруулах үйлдвэрүүд байгаатай холбоотой худалдаа болон боловсруулах үйлдвэрүүд өртгийн сүлжээнээс 10 хувийн ашгийг хуваалцдаг.

Ажлын байр бий болгох

Ноолуурын салбар нь **7,584 ажлын байр бий болгож байгаагийн** 87% бүтэн цагийн 13% нь хагас цагийн ажилчид байна. Ноолуурын өртгийн сүлжээний нийт цалингийн хэмжээ 96,206 сая MNT (€29.1 сая) байна. Бүтэн цагийн ажилчдын 55 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж цалингийн сангийн 57 хувийг авч байна. Ихэнх нь мэргэжлийн биш хүмүүс ажиллаж байна. Үйлдвэрүүдийг ангилж 34 угаах үйлдвэр, 46 хувь самнах, 16 ээрэх, 80 жижиг дунд үйлдвэрүүд эцсийн бүтээгдэхүүн боловсруулах салбарт ажиллаж байна.

Ноолуурын өртгийн сүлжээгээр буй болсон эдийн засгийн өсөлт нь хүртээмж сайнтай байна. Энэхүү өртгийн сүлжээ нь янз бүрийн насны эмэгтэйчүүдийг ажлын байраар хангахаас гадна боловсруулах өртгийн сүлжээний цалингийн хэмжээ улсын дундажтай ижил байна. Нүүдэлчин амьдралын хэв маягийн бэрхшээлээс үүдэн малчид эмзэг бүлэгт тооцогддог ч ноолуурын өртгийн сүлжээний орлого нь Монгол Улсад нүүдэлчдийн тогтвортой оршин тогтноход хувь нэмрээ оруулж байна.

Ноолуурын өртгийн сүлжээ нийгэм талаасаа тогтвортой эсэх?

Нийгмийн асуудлыг зургаан чухал үзүүлэлтээр дараах хүснэгтэд үнэлж үзүүлээ.

Ажиллах нөхцөл	- Бэлчээрийн мал маллагаа уламжлалт амьжиргааны чухал хэсэг гэж үнэлэгддэг ч залуучууд ялангуяа охид хөдөө үлдэж малчин болохыг хүсэхгүй байна - Боловсруулалтын салбар нь цалин сайтай, хөдөлмөрийн эрхийг дээдэлсэн ерөнхийдөө сонирхол татахуйц ажил байдаг ч хөдөлмөрлөх эрх, хүүхдийн хөдөлмөр, хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудал яригдаж байна
Газар, усны эрх	Бэлчээрийн зүй зохистой ашиглах хууль эрх зүйн зохицуулалт сул тул малчид цаг хүндэрсэн, хүйтэн үед эрсдэлтэй хол нүүдэл хийж байна
Жендерийн тэгш байдал	- Ноолуур боловсруулах салбарт эмэгтэйчүүд нэлээдгүй ажил эрхлүүлж, таатай цалин урамшуулал авдаг ба эмэгтэйчүүдэд манлайлах боломжууд их байна. - Малчин эмэгтэйчүүдийн газар, мал, өрхийн томоохон хөрөнгийн өмчлөлийн бүртгэл сул, зээлийн хүртээмж эрчүүдээс сул байна. - Дундаж орлоготой олон оронтой харьцуулахад малчин эмэгтэйчүүдийн тэгш бус байдал бага байгаа хэдий ч шийдвэр гаргах, манлайлах түвшинд тэднийг ялгаварлан гадуурхах явдлууд гарсаар байгаа болон ажлын ачаалал ихтэй байна. .
Хүнсний хангамж, шим тэжээлийн хүрэлцээтэй байдал	- Хоолны янз байдал дутагдалтай байна, өөх тос ихтэй хоол өргөн хэрэглэж байгаа нь малчдын эрүүл мэндэд муугаар нөлөөлж байна. - Бусад төрлийн зээлтэй холбоотой өрийн асуудал үүсээгүй ба хэрэглээний зардлаа нөхөхийн тулд малчдын малчны зээлийн ашигладаг ба энэ ач холбогдолтой байна гэж үзэхээр байна. Малын индексжүүлсэн даатгал нь дизайны хувьд чухал хэдий ч малчид зүй бус хорогдлын хувь хэмжээнд хүрээгүй гэдэг шалтгаанаар хохирлоо барагдуулж чадахгүй байгаа тул малчид даатгуулах сонирхол бага байна.
Нийгмийн капитал	- Бэлчээрийг зүй зохистой ашиглахын тулд бэлчээр ашиглагчдын хэсгийн (БАХ) тоо жил ирэх тусам нэмэгдэж байна. - Малчид хоршоо болон ажиллах нь ихсэж байгаа ч малчдын гишүүнчлэлийн түвшин доогуур байна (нийт малчдын 3/1 нь хоршооны зохион байгуулалтад орсон байна) - Малчид багийн хуралд маш идэвхтэй хамрагдаж байна. - Мэдээллийн урсгал сайтай, илүү нэгдсэн өртгийн дэд сүлжээнд өндөр түвшний итгэлцэл байна. .
Амьдрах нөхцөл	Хөдөө орон нутагт боловсрол олгохтой холбоотой асуудлууд байгаа хэдий ч эрүүл мэндийн үйлчилгээ, орон байраар хангах, боловсролын үйлчилгээ сайн байна.




График 6. Нийгмийн байдал

Өртгийн сүлжээ нь байгаль орчин талаасаа тогтвортой эсэх?

Хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөө

Region	Percentage
Ямаа	70%
Угаах	1%
Самнах	0%
Будах	14%
Ээрэх	5%
Сүлжих	5%
Эцсийн	5%

Өртгийн сүлжээний байгалийн нөөцийн хомсдол болон уур амьсгалын өөрчлөлт үзүүлэх нөлөө

Боловсруулах үйлдвэрүүдийн химийн бодисын хэрэглээ

8

байна. Байгаль будгийг хаях **нь усны эвтрофикаци** (химийн хүчилтөрөгчийн хэрэгцээ, нийт фосфор, нийт азот ба $\text{NH}_3\text{-N}$ -ийн ялгаралтаас шалтгаалж), **усны хорт чанарт** (хром, анилин, шингээх боломжтой органик галоген ялгасдаг зэргээс шалтгаална) нөлөөлдөг.

Ноолуурын ямаа нь бэлчээрийг доройтуулах нэг хүчин зүйл болж байна

Монгол оронд бэлчээрийн доройтол жил ирэх тусам нэмэгдэж байгаад ноолуурын ямааны тоо толгойн өсөлт үүнд хувь нэмрээ тодорхой хэмжээнд оруулж байна. Зах зээлийн үнийн өсөлтийг даган малчид ямааны тоо толгойг ихэсгэх сонирхол их байна түүнчлэн малчид зах зээлд ойртох боломжийг илэрхийлэн хот суурин газар руу илүү төвлөрч байгаа нь цэгэн доройтлыг ихээр үүсгэж байна. Бэлчээрийн ачаалал нэмэгдэж байгаа нь бэлчээрийн ургамлын зүйлийн баялаг болоод малын тэжээлийн бодисын хомсдолыг үүсгэж байна. Цаашлаад бэлчээрийн доройтол нь биологийн олон янз байдал нэн ялангуяа зэрлэг амьтны амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Байгаль орчинд үзүүлэх нөлөө нь ноолуурын өртгийн сүлжээний хоёр шатанд илэрч байна: Мал маллагаа болон ноолуур будах үе шат. Ноолуурын ямааны байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөө нь метан хийн ялгарал ба бэлчээрийн доройтол гэдгийг илүү ухамсарлан ойлгох нь чухлаар тавигдаж байна. Ноолуур будах үйл явцын тухайд усны хаягдал, эрчим хүчний хэрэглээ, ялангуяа нүүрсний хэрэглээнээс үүдэлтэй бохирдолд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй байна.

Дүгнэлт болон зөвлөмж

Ноолуурын өртгийн сүлжээ нь хөдөөгийн малчдын амьжиргааны эх үүсвэр, суурин газарт ажлын байр бий болгох бөгөөд үндэсний эдийн засгийн өсөлт, экспортыг төрөлжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна. Хэдий тийм боловч ноолуур бэлтгэлийн үеэр ноолуурын үнэ өндөр байдаг нь үндэсний боловсруулах үйлдвэрүүд өндөр хүүтэй зээл авах шаардлага гардаг нь үйлдвэрүүдийн эдийн засгийн нөхцөл байдалд нөлөөлж байна. Энэ нь үндэсний үйлдвэрүүд нь БНХАУ-ын өртөг багатай зах зээлтэй өрсөлдөх чадварыг улам бүр сулруулж байна. Мөн байгаль орчны талаас анхаарах шаардлагатай хэд хэдэн асуудлууд (бэлчээрийн доройтол, сэргээгдэх эрчим хүч ашиглах, ус ашиглалтын менежментийг сайруулах, мал аж ахуйгаас ялгарах хүлэмжийн хийн асуудал гэх мэт) байна.

Зөвлөмж

Монгол Улс, өндөр чанарын баталгаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар үнээ өсгөх, малчид, бэлчээрийн зохистой ашиглалт руу чиглэсэн зөв бодлого, үйл ажиллагаа явуулснаар цөөн ямаанаас илүү орлоготой болох боломжтой. Ноолуурын өртгийн сүлжээнд хийсэн судалгаан үр дүнгээс дараах зөвлөмжүүдийн хүргэж байна.

Малчдын түвшинд

- Бэлчээр зохион байгуулах эрх зүйн орчинг сайжруулах: Бэлчээр ашиглалтын хэсэг, малчдын хоршооны үйл ажиллагааг бэхжүүлэх замаар бэлчээрийг төлөв байдлыг сайжруулах малчдыг хүйтний улиралд холын нүүдэл хийхээс сэргийлэх.
- Мал амьтны эрүүл мэндийн үйлчилгээний менежмент, харилцаа холбоог малчдын түвшинд сайжруулах болон мал аж ахуйн үйлдвэрлэлийн зөвлөгөөг өгөх замаар малчдыг дэмжиж ажиллах
- Ноолуураас гадна малын гаралтай бусад бүтээгдэхүүний өртгийн сүлжээг сайжруулах нь чухал байна.

Боловсруулах үйлдвэрийн түвшинд

- Байгаль орчны сөрөг нөлөөг багасгахын тулд i) сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх, ii) химийн бодисын зохистой ашиглалт, бохир усыг цэвэрлэхэд мөрдөж буй стандартуудыг мөрдүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ногоон гэрчилгээтэй химийн бодисуудыг түлхүү ашиглах
- Боловсруулах үйл ажиллагааны чанарыг дэмжих, ялангуяа самнах үйлдвэрийн хүчин чадлыг сайжруулах. Улаанбаатар хотоос гаднах бүсэд байрлах боловсруулах төвүүдийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Худалдаа болон экспорт

- Стандартуудын мөрдөлт болон сайн дурын шошгололт дээр өртгийн сүлжээний тоглогчдын хамтын ажиллагааг дэмжих: үүнд малын эрүүл мэндийн асуудалд анхаарч хамруулах, малчдын тогтмол орлогыг баталгаажуулах, өндөр чанартай үйлдвэрлэлийг урамшуулах, стандарт болон шошгололтын схемчлэлийг экспортлогч компаниудад идэвхтэй сурталчлах замаар өндөр чанартай монгол ноолуурын эрэлтийг нэмэгдүүлэх.

- Ноолуурын өртгийн сүлжээний тоглогчдын мөнгөн урсгалын боломжийг нэмэгдүүлэх механизмыг хөхүүлэн дэмжих, Малчдын гишүүнчлэл бүхий хоршоодыг бодлогын таатай орчин бүрдүүлж, чадавхыг бэхжүүлэх замаар дэмжинэ.
- Дуудлага худалдааны загвараар чанарт суурилсан үнийн тогтолцоог чангатгах.

Өртгийн сүлжээний шинжилгээг VCA4D төслийн хүрээнд Европын Холбооноос санхүүжүүлж, Агринтура- (<http://agrinatura-eu.eu>) судалгааны хүрээлэн, Европын их дээд сургуулиудын холбоо, хөдөө аж ахуйн судалгааны чиглэлээр мэргэшсэн судалгааны төвүүд хамтран түнш орнуудын өртгийн сүлжээг сайжруулах зорилгоор хэрэгжүүлсэн.

Ноолуурын өртгийн сүлжээнд хийсэн шинжилгээ нь бодлогын чиг баримжаа гаргах, хэлэлцүүлэг хийх, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг мэдээллээр хангахад тусална. Өртгийн сүлжээний шинжилгээ нь хөдөө аж ахуй, усны амьтны үржүүлэг болоод загасны аж ахуй мэтийн сүлжээ нь зах зээлийн зарчимд таарч байгаа эсэхийг ойлгоход тустай. Шинжилгээ нь өртгийн сүлжээний байгаль орчин, нийгэм, жижиг бизнес эрхэгчдэд үзүүлэх үр нөлөөг үнэлдэг. Европын Холбооноос өртгийн сүлжээний нэгдсэн аргачлалыг стандартчилж өгсөн. Дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбоосоор авах боломжтой: https://capacity4dev.europa.eu/projects/value-chain-analysis-for-development-vca4d/info/246-mongolia-cashmere_en

Багийн гишүүд: Morton, J., Kotyza, P., Vigne, M., Dashbal, B. 2024. Монгол улсын ноолуурын өртгийн сүлжээний шинжилгээний Европын Холбоонд (DG INTPA буюу Олон Улсын түншлэлийн газар) гаргах тайлан, . Өртгийн сүлжээг хөгжүүлэх шинжилгээ (VCA4D CTR 2017/392-416), 211 р + хавсралт. Зохиогчид зөвхөн тайлангийн эх хувьд хариуцлага хүлээнэ



**Funded by
the European Union**